

**ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТУУД**

**ХАВСРАЛТ №2. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ  
2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020 оны 12 дугаар сарын 16				Улаанбаатар хот
№	Хөтөлбөрийн үндсэн чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
<b>Нэг. Ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр</b>				
1	Харьяалах хэлтсийн удирдах албан тушаалтан хагас жилд нэг удаа албан хаагч нартай ганцаарчилсан болон хэсэгчилсэн уулзалт зохион байгуулж хоорондын харилцаа, ажлын байран дахь сэтгэл ханамжийн аятай нөхцөлийг бүрдүүлэх	Хувийн зохион байгуулалт, ажлын байрны эмх цэгцийг сайжруулах талаар уулзалт хийх	Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах талаар уулзалтыг 2020 оны 1-р улиралд зохион байгуулав.	100 хувь
		Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга хийх	Албан хаагчидтай хийсэн уулзалтаас гарсан саналын дагуу 9 албан хаагчийн ажиллах орчныг сайжруулж ажлын өрөөний хэмжээг томруулсан. 4 албан хаагчийн компьютер, 1 албан хаагчийн принтерийг шинэчлэн 20 компьютерт вирусийн эсрэг програм суулгав.	100 хувь
2	Нийтээр тэмдэглэх баяр ёслол, тэмдэглэлт ойг тохиолдуулан албан хаагчдад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах	Дэлхийн аялал жуулчлалын өдөр, Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрөөх ажлыг зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2020 оны А/108 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг түр зогсоосон.	-
<b>Хоёр. Эрүүл мэндийн чиглэлээр</b>				
3	Албан хаагчдыг жилд 1 удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах	Албан хаагчдыг Д витамин, эрдсийн багц шинжилгээнд хамруулав.	100 хувь

4	Албан хаагчдад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгох	Ажлын байран дахь дасгал хөдөлгөөнүүдийг хийх, хэвшүүлэх	Албан хаагчид ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өдөрт 2 удаа 11:00, 15:00 цагуудад тогтмол хийж хэвшив.	100 хувь
		Эрүүл мэндийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2020 оны А/108, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/1242 дугаар захирамжаар олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг түр зогсоосон тул сургалт зохион байгуулах боломжгүй болсон.	-
5	"Эрүүл агаар-Хөдөлгөөн" уриан дор амралт явган аяллыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах	Явган аялал зохион байгуулах	Тус газраас “Улаанбаатар” явган аяллын фестивалийг 2 дахь жилдээ зохион байгуулсан. Явган аялалд тус газрын нийт албан хаагчид болон Монгол, Солонгос хоёр улсын 150 гаруй алхагч Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын “Монгол оллэ” явган аяллын 11 км маршрутаар алхалт хийв.	100 хувь
<b>Гурав. Цалин хөлс, урамшуулал олгох чиглэлээр</b>				
6	Улсын Их Хурал, Засгийн газраас батлагдсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчийн цалинг тухай бүр шинэчлэн тогтоож, мөрдөх	Улсын Их Хурал, Засгийн газраас батлагдсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчийн цалинг тухай бүр шинэчлэн тогтоож, мөрдөх	Монгол Улсын Засгийн газрын “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2019 оны 472 дугаар тогтоолын дагуу цалин хөлсийг олгож байна.	100 хувь
7	Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох асуудлаар жилд	Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ ажилласан жил, зэрэг дэв, эрдмийн цол, зэрэг, мэргэшлийн зэргийн судалгааг хийх	Албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэвийн судалгааг 2020 оны 1, 6 дугаар саруудад шинэчлэв.	100 хувь



	2 удаа судалгаа хийж шаардлага хангасан албан хаагчдыг тодорхойлон газрын дарга болон дээд шатны байгууллагад танилцуулан шийдвэрлэх	Шаардлага хангасан албан хаагчдыг тодорхойлон газрын дарга болон дээд шатны байгууллагад танилцуулах	2020 оны 1 дүгээр сард хийсэн албан хаагчдын ажилласан жил, зэрэг дэвийн судалгаа, гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн 4 албан хаагчийн зэрэг дэв нэмэгдүүлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.	100 хувь
		Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу олгох	Нийслэлийн Засаг даргын “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/452 дугаар захирамжийн дагуу 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг олгов.	100 хувь
8	Албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг нэмэгдүүлэх буюу бууруулах асуудлыг албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний улирлын үнэлгээг үндэслэн нэмэгдүүлэх буюу бууруулах холбогдох хууль, дүрэм журмын дагуу шийдвэрлүүлэх.	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний улирлын үнэлгээг үндэслэн 5 албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээний шатлалыг газрын даргын 2020 оны А/02 дугаар тушаалаар нэмэгдүүлэв.	100 хувь
9	Ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан идэвх зүтгэлийг үндэслэн төрийн одон медаль болон бусад шагналд тодорхойлох, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулах	Ажил үүргээ үр дүнтэй биелүүлж, өндөр амжилт гаргасан идэвх зүтгэлийг үндэслэн төрийн одон медаль болон бусад шагналд тодорхойлох	Нийт албан хаагчдын шагналын судалгааг тухай бүр шинэчилж, ажлын үр дүнг үндэслэн 1 албан хаагч “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар шагнагдаж, 1 албан хаагчийг “Алтан газар одон”-д тодорхойлов.	100 хувь
10	Албан хаагчийн оюуны бүтээл болон бүтээлч санал нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ туршлага нэвтрүүлсэн бол зохих хэмжээний урамшуулал олгох	Албан хаагчийн оюуны бүтээл болон бүтээлч санал нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, шинэ туршлага нэвтрүүлсэн бол зохих хэмжээний урамшуулал олгох	“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах шаардлага” гарын авлага боловсруулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн буюу 6 албан хаагчдад газрын даргын 2020 оны А/88 дугаар тушаалаар нийт 800.000 төгрөгийн урамшуулал олгов.	100 хувь



Дөрөв. Тусламж, тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор олгох чиглэлээр

11	Албан хаагчийн эхнэр, нөхөр, хүүхэд, эцэг, эх, эмээ өвөө, ах, эгч, дүү нас барсан тохиолдолд буцалтгүй тусламж үзүүлэх	Хөдөлмөрийн дотоод журмын 8.7.1 дэх заалтын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээний мөнгөн тусламж үзүүлэх	Байхгүй	-
12	Анх удаа гэр бүл болсон албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлэх	Анх удаа гэр бүл болсон албан хаагчдад буцалтгүй тусламж үзүүлэх	Анх удаа гэр бүл болсон албан хаагч байхгүй.	-
13	Гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн бол буцалтгүй тусламж үзүүлэх	Хөдөлмөрийн дотоод журмын 8.10 дэх заалтын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж үзүүлэх	Газрын даргын 2020 оны Б/30 тушаалаар гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 2 албан хаагчид тус бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгов.	100 хувь
14	Албан хаагчдад сар бүр унаа хоолны мөнгө олгох	Албан хаагчдад сар бүр унаа хоолны мөнгө олгох	Албан хаагчдад сар бүр унаа хоолны мөнгийг батлагдсан төсвийн хүрээнд олгож байна.	100 хувь
15	Ар гэрт нь гачигдал гарах, эрүүл мэндийн байдлаас эмчлүүлэх, сувилуулах, эцэг эхийн насны ой тэмдэглэх, үр хүүхэд төрсөн ах дүү нь хуримаа хийх, диплом эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгох	Ар гэрт нь гачигдал гарах, эрүүл мэндийн байдлаас эмчлүүлэх, сувилуулах, эцэг эхийн насны ой тэмдэглэх, үр хүүхэд төрсөн ах дүү нь хуримаа хийх, диплом эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгох	Байхгүй.	-
16	Бусад тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгоход холбогдох журамд заасны дагуу шийдвэрлэх	Бусад тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгоход холбогдох журамд заасны дагуу шийдвэрлэх	Байхгүй	-
Тав. Гэр бүлийг дэмжих чиглэлээр				




17	Албан хаагчийн амьдарч буй орон байр, орчин нөхцөл, гэр бүлийн гишүүний боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг мэдээллийг цуглуулан судалгаа гаргаж тухай бүр баяжилт хийх	Албан хаагчийн амьдарч буй орон байр, орчин нөхцөл, гэр бүлийн гишүүний боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг мэдээллийг цуглуулан судалгаа гаргаж тухай бүр баяжилт хийх	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу албан хаагчдын хувийн хэргийг хөтөлж, баяжилтыг тухай бүр хийсэн.	100 хувь
18	Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын 0-16 насны хүүхдэд бэлэг өгөх	Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр албан хаагчдын 0-16 насны хүүхдэд бэлэг өгөх ажлын зохион байгуулах	Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр газрын даргын 2020 оны А/35 тушаалаар Эцэг эхийн зөвлөл албан хаагчдын 37 хүүхдүүдэд бэлэг өгөх ажлыг байгууллагын зохион байгуулав.	100 хувь
<b>Зургаа. Сургалтад хамруулж, мэргэшүүлэх чиглэлээр</b>				
19	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	"Мэдээллийн цаг"-ийн хуваарийг гаргаж албан хаагчдад шинэ соргог мэдээллийг өгч, мэдлэг чадвар сайжруулах ажлыг зохион байгуулах	"Мэдээллийн цаг"-ийг батлагдсан хуваарийн дагуу 4 удаа зохион байгуулж хэлтэс бүр хийх ажлын төлөвлөгөө, албан хаагчдад эрүүл мэндийн болон цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэв.	100 хувь
		Дээд газраас зохион байгуулсан сургалтуудад нийт албан хаагчдыг хамруулах	Дээд газраас зохион байгуулсан 11 сургалтад давхардсан тоогоор 24 албан хаагч хамрагдав. /Сургалтын төлөвлөгөөний биелэлтэд хавсаргав/	100 хувь
		ТАЗ-ийн Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албаны тухай хууль бусад журам хөтөлбөрийг танилцуулах сурталчлах сургалтыг албан байгууллагадаа зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт судалгааны төвтэй хамтран албан хаагчдад зориулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Хууль эрх зүй" сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав. Сургалт зохион байгуулахдаа халдвар хамгаалалтыг дэглэмийг мөрдөж 2 ээлжээр нийт 20 албан хаагчийг хамруулсан.	100 хувь
		Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтад хамруулах	-	-

20	Албан хаагчийн гадаад хэлний мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Англи хэлний анхан шатны сургалтад нийт албан хаагчдыг хамруулах	Газрын даргын 2020 оны А/92 тушаалаар англи хэлний анхан шатны цахим сургалтад албан хаагчдыг хамруулав.	100 хувь
21	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх үед ажлаас түр чөлөөлөх, эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг олгох зэргээр төрийн албан хаагчийн мэдлэг боловсрол мэргэшлээ дээшлүүлэх бололцоогоор хангах	Албан хаагчдыг гадаад, дотоодын их дээд сургуульд мэргэшлийн чиглэлээр давтан сурахад байгууллагаас суралцах нөхцөлийг хангах	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдаж байгаа 1 албан хаагчийг сурах нөхцлөөр хангаж ажлыг цагаас чөлөөлөв.	100 хувь
		Албан хаагч өөрийн хүсэлтээр суралцахад нь хууль тогтоомж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу дэмжлэг үзүүлэх	- Тайлбар	-
Нийт				100 хувь

ТАНИЛЦСАН:  
ДАРГА

ХЯНАСАН:  
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:  
ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН



А.АРИУНГЭРЭЛ

Ц.ЭНХТҮВШИН

С.БАЯРЖАРГАЛ